



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 10 өдөр

Дугаар A/08

Арвайхээр

Г Т

### Түр журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.6, 32 дугаар зүйлийн 32.1.3, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах” тухай 03 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд тус аймгийн бүх сумдын малчин өрхөд малын тэжээл олгох ажлыг зохион байгуулах түр журмыг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, гадны аймагт оторлож байгаа болон өөрийн аймаг, сумандaa өвөлжиж байгаа малчин өрхөд тэжээл олгох ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Түр журам, Ажлын төлөвлөгөөний дагуу тэжээл олгох ажлыг шуурхай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100020

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны...  
дугаар сарын 12-ны өдрийн ...-дүгээр  
захирамжийн нэгдүгээр хавсралт

## ТУС АЙМГИЙН БҮХ СУМДЫН МАЛЧИН ӨРХӨД МАЛЫН ТЭЖЭЭЛ ОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү түр журмын зорилго нь Дэлхийн банкны хөнгөлттэй зээлийн санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хэрэгжүүлж байгаа “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл (МАА-н ЭЗЭН төсөл)-ийн эх үүсвэрийн 4.2 тэр бум төгрөгийн хөрөнгөөр зохих журмын дагуу малын хүчит тэжээлийг Өвөрхангай аймгийн бүх сумдын болон гадны аймагт отроор явж байгаа малчин өрхөд тусlamж үзүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулахад оршино.

1.2. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар тушаалын “Түр журам”, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл” -ийн болзошгүй Онцгой нөхцөл байдал, гамшгийн үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсгийн заавар болон бусад мэргэжлийн байгууллагын түр журам, зааварт үндэслэсэн болно.

### Хоёр. Хүнс, хөдөө аж ахуйн газрын үүрэг

2.1. Тэжээл хүргэх сумдын жагсаалт, сумдад тэжээлийг хүлээлгэн өгөх, холбогдох зардлын тооцоог гаргах, түүнчлэн гадны аймагт оторлож байгаа малчин өрхөд хүргэх ажлыг хариуцаж, холбогдох зардлыг тооцох;

2.2. Тэжээл тээвэрлэлт, хадгалалт, хүргэлт, тараалтын үед тээвэрлэн хүргүүлсэн, хүлээн авсан санхүүгийн баримт, зарлагын баримт, төлбөр тооцоо, шаардлагатай бусад холбогдох баримт бичгүүдийг Дэлхийн банкны шаардлагад нийцсэн загварын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, МАА-н ЭЗЭН төсөлд хүргүүлэх;

2.3. Нийт тусlamжид хамрагдах малчин өрхийн судалгаа мэдээллийг Дэлхийн банкны шаардлагад нийцсэн загварын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, МАА-н ЭЗЭН төсөлд хүргүүлэх;

2.4. Аймгаас сум, багийн төв хүртэл тээвэрлэгдэж буй тэжээлийн төрөл, хэмжээ, зам, маршрут, хүлээн авах цэгт очих боломжит хугацааг тодорхойлж сумын Онцгой комисст шуурхай мэдээлэх;

2.5. Зудын эрсдэл өндөр байгаа сумдад тэжээлийг түрүүлж хүргэх ажлыг зохион байгуулж, шуурхай ажиллах;

### Гурав. Онцгой байдлын газрын үүрэг

3.1. Улсын нөөцийн салбарын агуулахыг бараа хүлээн авах бэлэн байдлыг хангах, тээвэрлэгдэж ирсэн тэжээлийг бүртгэх, ачиж буулгах, сумд руу тээвэрлэх ажлыг аймгийн ХХААГ-аас гаргасан хуваарийн дагуу хамтран гүйцэтгэх;

3.2. Аймгийн төвд тээвэрлэн ирсэн тэжээлийг Онцгой байдлын газар, хэлтсийн аврах, гал унтраах анги, улсын нөөцийн салбарын бие бүрэлдэхүүний хүчээр ачиж буулгах, хадгалах ажлыг шуурхай зохион байгуулах;

## **Дөрөв. Зэвсэгт хүчний 0256 дугаар ангийн үүрэг**

4.1. Тээвэрлэсэн ирсэн тэжээлийг Улсын нөөцийн салбар цэгт буулгах, сумдруу ачих ажлыг зохион байгуулж, хүн хүчээр хангах;

4.2. Тээвэрлэсэн ирсэн тэжээлийг Улсын нөөцийн салбар цэгт буулгах, сумдруу ачихад оролцох алба хаагчдыг /цэрэг/ өөрийн унаагаар хангахад;

### **Тав. Цагдаагийн газрын үүрэг**

5.1. Гурил тэжээлийн үйлдвэрээс аймгийн төв, аймгийн төвөөс сумын төв, сумын төвөөс малчин хүртэлх зам маршрутын дагуу тэжээл тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, шалган нэвтрүүлэх цэгүүдээр саадгүй нэвтрүүлэх, хяналт тавих, цаг агаарын болзошгүй хүндрэлтэй нөхцөлд жолооч, тээврийн хэрэгсэл хүрч очих газарт нь саадгүй хүргэхэд дэмжлэг үзүүлэх;

### **Зургаа. Сумын Засаг дарга нарын үүрэг**

6.1. Сумдын Засаг даргын Тамгын газар, сумын Онцгой комисс нь тэжээл хүлээн авах, малчин өрхөд тараах 3-5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон ажиллуулж, малчин өрхийн мэдээллийг зохих зааврын дагуу гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэх;

6.2. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд тэжээл хүлээн авах малчин өрх сумас өөрийн зардлаар авах талаар дэмжлэг авах малчин өрх бүрт зар хүргэх бөгөөд малчин өрхийн тэргүүн болон түүнийг итгэмжлэгдсэн этгээдэд тэдгээрийн иргэний үнэмлэх, регистрийн дугаар, бүртгэлтэй гар утасны дугаар бүхий бүртгэл жагсаалтын дагуу тэжээлийг олгосон, хүлээн авсан тухай баримтыг гарын үсэг, малчны тамгаар баталгаажуулан баримтжуулж гурван хувь үйлдэн хоёр хувийг зарлагын баримт (падаан) хавсарган Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах.

6.3. Тэжээлийг ирж авах боломжгүй малчин өрхийн тэжээлийг шаардлагатай бол сумын Онцгой комиссиоос хүргэж өгөх ажлыг зохион байгуулах;

6.4. Суманд тэжээл хүлээн авах, хадгалах хашаа саравч бэлтгэх ажлыг зохион байгуулах, Дэлхийн банкны шаардлагад нийцсэн МАА-н ЭЗЭН төслөөс гаргасан загварын дагуу цахим бүртгэл хийж программд мэдээлэл оруулах; /холбогдох зураг бусад мэдээлэл/

6.5. Үйл ажиллагааны тайлан, санхүүгийн холбогдох баримтыг 2 долоо хоног тутамд Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэх;

### **Долоо. Бусад**

7.1. Энэхүү түр журмыг зөрчсөн этгээд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Аймгийн Засаг даргын 2021 оны 01  
дугаар сарын 10-ны өдрийн дүгээр  
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга  
Гишүүд: Д.Одонбаяр –аймгийн Онцгой байдлын газрын дарга  
дэд хурандаа  
О.Ганбат -аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа  
С.Дуламсүрэн –аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн  
хяналтын газрын дарга  
Д.Галбадрах -Зэвсэгт хүчний 0256 дугаар ангийн захирагч,  
хурандаа  
Г.Батцэцэг –аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж  
ахуйн газрын нягтлан бодогч  
Сумдын Засаг дарга нар  
Нарийн бичгийн дарга: Т.Эрдэнэбаяр –аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс,  
хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны  
Бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан  
мэргэжилтэн

-оOo-

Аймгийн Засаг даргын 2021 оны 01  
дугаар сарын 12-ны өдрийн 108-дүгээр  
захирамхийн туравдугаар хавсралт

**ГАДНЫ АЙМАГТ ОТОРЛОЖ БАЙГАА БОЛОН ӨӨРИЙН АЙМАГ  
СУМАНДАА ӨВӨЛЖИЖ БАЙГАА МАЛЧИН ӨРХӨД ТЭЖЭЭЛ ОЛГОХ АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
Нэг. Бэлтгэл ажлыг хангах талаар			
1.	Малчин өрхийн судалгааг нарийвчлан гаргах	2021 оны 01 дүгээр сарын 11-13-ны хооронд	ХХААГазар, Сумын Засаг даргын тамгын газар
2.	Сум тус бүрт хүргэх тэжээлийн хэмжээ /тонн/, шаардагдах автомашин тооцоо, хуваарь гаргах	2021 оны 01 дүгээр сарын 11-15-ны хооронд	ХХААГазар
3.	Тэжээл хүргэх сумын тэжээл тээвэрлэх зам маршрутыг товлох	2021 оны 01 дүгээр сарын 11-15-ны хооронд	ХХААГазар
4.	Сумдын Онцгой комиссын дэргэд тэжээл хүлээн авах бэлэн байдлыг хангах, бүртгэх, ачиж буулгах, малчин өрхөд хүлээлгэж өгөх ажлын хэсэг байгуулах	2021 оны 01 дүгээр сарын 11-15-ны хооронд	Сумдын Онцгой комисс, ЗДТГ
5.	Улсын нөөцийн салбарын агуулахын бэлэн байдлыг хангах	2021 оны 01 дүгээр сарын 11-13-ны хооронд	Онцгой байдлын газар
Хоёр. Тэжээл сумдруу тээвэрлэх, малчдад хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулах талаар			
6.	Эхний удаад ирсэн тэжээлийг хамгийн эрсдэлтэй байгаа сумдад хувиарлах, хүргэх	2021 оны 01 дүгээр сарын 18-22-ны хооронд	ХХААГазар
7.	Тээвэрлэн ирсэн тэжээлийг буулгах, сумдруу ачих ажлыг зохион байгуулах	2021 оны 01 дүгээр сарын 11-ээс 04 сарын 01 хүртэл	Онцгой байдлын газар, ЗХ-ний 256-р анги
8.	Малчин өрх бүрт олгох тэжээлийг хүлээн авах, малчдад тараах ажлыг зохион байгуулах	2021 оны 01 дүгээр сарын 18-22-ны хооронд	Сумдын Онцгой комисс, ЗДТГ
9.	Цаг агаарын байдлаас зам даваа хаагдах, онц байдлын үед шаардагдах хүн хүч, техникийн тусламж үзүүлэх	2021 оны 01 дүгээр сарын 11-ээс 04 сарын 01 хүртэл	Онцгой байдлын газар, Сумдын онцгой комисс, ЗДТГ
10.	Тэжээл тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн зам хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, шалган нэвтрүүлэх товчоо, цэгүүдээр саадгүй нэвтрүүлэх	2021 оны 01 дүгээр сарын 11-ээс 04 сарын 01 хүртэл	Цагдаагийн газар
11.	Тэжээлийг сумдуудад хүргэсэн, малчин өрхүүдэд олгосон үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нэгтгэж ажлын хэсгийн хуралд танилцуулан тайлгаха	2021 оны 04 дүгээр сарын 10-ны дотор	ХХААГазар